

**АГУУЛГА**

<b>1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ</b> .....	<b>5</b>
1.1 Зорилго.....	5
1.2 Хамрах хүрээ.....	5
1.3 Нэр томъёоны тайлбар.....	5
<b>2. БОДЛОГО</b> .....	<b>5</b>
2.1 Тогтвортой хөгжлийн бодлого .....	6
2.2 Тогтвортой хөгжлийн зорилго, зорилт.....	6
2.3 Зарчим.....	5
<b>3. МАНЛАЙЛАЛ БА ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА</b> .....	<b>9</b>
3.1 Тогтвортой хөгжлийн бодлогын хариуцлагын матриц.....	9

## 1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### 1.1 Зорилго

1.1.1 “Говь” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Тогтвортой хөгжлийн бодлого нь байгаль орчин, нийгэм, засаглалын хүрээнд компанийн үйл ажиллагааг урт хугацаанд тогтвортой явуулах, бүтээмж болон үнэ цэнийг нэмэгдүүлэх, эрсдэл ба боломжийн хяналтыг сайжруулахад оршино.

1.1.2 Энэхүү бодлогыг Нэгдсэн Үндэсний Байгууллагын Тогтвортой хөгжлийн 17 зорилго, Даян Дэлхийн Гэрээний 10 зарчмын хүрээнд бизнесийн үйл ажиллагаандаа нийцүүлэн боловсруулж, зорилтуудыг хэрэгжүүлэхдээ уг бодлогын зарчмыг баримтлан ажиллана.

### 1.2 Хамрах хүрээ

1.2.1 Энэхүү бодлого нь олон нийтэд нээлттэй байх бөгөөд компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх), Гүйцэтгэх удирдлага, нийт ажилтнууд, охин компаниуд, ханган нийлүүлэгчид болон бусад сонирхогч талуудад хамаарна.

1.2.2 Энэхүү бодлого нь компанийн бусад холбогдох дүрэм, бодлого, журам, заавартай нийцсэн байх бөгөөд үндсэн үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн байна.

1.2.3 Бодлогын баримт бичгийг удирдлага, байгаль орчин, нийгэм, засаглал, салбарын үйл ажиллагаа гэсэн 5 хамрах хүрээнд зорилтуудыг тусган боловсруулсан болно.

### 1.3 Нэр томъёоны тайлбар

1.3.1 **Мерит зарчим:** Нийгмийн гарал үүсэл зэргийг үл харгалзан хувь хүнийг авьяас, хичээл зүтгэл, ур чадварын шалгуураар нь урамшуулах, ажилд дэвшүүлэх зарчим;

1.3.2 **Нийлүүлэлтийн гинжин хэлхээ:** Түүхий эд бэлтгэлээс бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр дамжин эцсийн хэрэглэгчид хүргэх үйл ажиллагаа, мэдээлэл болон үйлчилгээ;

1.3.3 **Сонирхогч тал:** Байгууллагын үйл ажиллагаа, шийдвэрт нөлөөлөх эсвэл түүний нөлөөнд орж болох байгууллага болон хувь хүн;

1.3.4 **Тогтвортой түүхий ноолуур:** Бэлчээрийн төлөв байдал, малын эрүүл мэнд, мал сүргийн тавлаг байдал, хариуцлагатай малчин, зохистой төлбөр, түүхий эдийн чанар, аюулгүй байдал зэрэг шаардлагыг хангасан түүхий ноолуур;

1.3.5 **Тогтвортой хөгжил:** Өнөө үеийн хэрэгцээг хангахдаа ирээдүй үеийн хэрэгцээгээ хангах боломжийг хязгаарлахгүй байх;

- 1.3.6 **Хаягдалгүй эдийн засаг:** Анхнаас нь дахин хэрэглэж болох бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, улмаар хэмнэлттэй, үр дүнтэй, ашигтай байх нөхцлийг бүрдүүлэх эдийн засгийн загвар;
- 1.3.7 **Хариуцлагатай татан авалт:** Ханган нийлүүлэгчдийг сонгох, тэдгээрээс худалдан авалт хийх, үйлчилгээ авахдаа байгаль орчин болон нийгэмд ээлтэй нөлөөллийг чухалчлах;
- 1.3.8 **Шууд бус үйл ажиллагаанаас хамаарах хүлэмжийн хий:** Компанийн худалдан авч ашигласан цахилгаан, дулаан, хөргөлт, уурын эрчим хүч гэх мэт;
- 1.3.9 **Шууд үйл ажиллагаанаас хамаарах хүлэмжийн хий:** Компанийн ашиглаж байгаа тээврийн хэрэгсэл, станц, машин техник, агааржуулагч, эрчим хүч үүсгүүр гэх мэт;

## 2. БОДЛОГО

### 2.1 Тогтвортой хөгжлийн бодлого

- 2.1.1 Нийлүүлэлтийн гинжин хэлхээнд сонирхогч талуудын ил тод, нээлттэй байдлыг ханган, компанийн тогтвортой хөгжлийн үзүүлэлтүүдийг тасралтгүй сайжруулах замаар Монгол ноолууран хувцсаа дэлхийд таниулна.

### 2.2 Тогтвортой хөгжлийн үйл ажиллагааны зорилт

- 2.2.1 Бодлогын хэрэгжилтийг жил бүр хянан, 2025 оны эцсийн байдлаар дараах зорилтуудыг бүрэн хангасан байна.
- 2.2.2 Байгаль орчин, нийгэм, засаглалын хүрээнд нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг 3 жил тутамд хийлгэн, түүний дагуу зорилтуудад өөрчлөлт, шинэчлэлт хийж болно.
- 2.2.3 Тогтвортой хөгжлийн удирдлага:
- 2.2.3.1 Компанийн богино, дунд, урт хугацааны төлөвлөгөөнд тогтвортой хөгжлийн зорилтуудыг тусган, хэрэгжилтийг хангаж, жилд нэг удаа үйл ажиллагааны тайланг гаргана. Байгаль орчин, нийгэм, засаглалын эрсдэлийг удирдах замаар үзүүлэлтүүдийг тасралтгүй сайжруулна.
- 2.2.4 Байгаль орчин:
- 2.2.4.1 ISO 14001:2015 Байгаль орчны удирдлагын тогтолцоог үйл ажиллагаандаа нэвтрүүлж, компанийн Байгаль орчны бодлогын хэрэгжилт, гүйцэтгэлийг жилд нэг удаа тайлагнана.
- 2.2.4.2 Хүлэмжийн хий, эрчим хүч, ус, хог хаягдал, химийн бодисын менежмент зэрэг үндсэн нөлөөллийн талаарх дата мэдээллийг тасралтгүй сайжруулан, үр ашигтай зарцуулалтыг нэмэгдүүлнэ.

- 2.2.4.3 Эрчим хүч: ISO 50001:2018 Эрчим хүчний удирдлагын тогтолцооны удирдамжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ.
- 2.2.4.4 Эрчим хүчний нийт хэрэглээг 15 хувиар бууруулж, компанийн шууд болон шууд бус үйл ажиллагаанаас хамаарах хүлэмжийн хийн ялгарлыг 10 хувиар бууруулна.
- 2.2.4.5 Үйл ажиллагаандаа сэргээгдэх эрчим хүчний хэрэглээг 20 хувиар нэмэгдүүлнэ.
- 2.2.4.6 Ус: Цэвэр болон бохир усны тоолуурыг сайжруулан, компанийн үйл ажиллагаанаас гарч байгаа ахуйн болон үйлдвэрийн бохир усны 10 хүртэлх хувийг дахин цэвэршүүлнэ.
- 2.2.4.7 Нийт хог хаягдлыг ангилан бүртгэлжүүлж, хог хаягдлын дахин боловсруулалтыг 30 хувиар нэмэгдүүлнэ.
- 2.2.4.8 Химийн бодис: Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн ногоон гэрчилгээтэй будаг болон химийн бодисыг хэрэглэн, стандартын дагуу ашиглана.
- 2.2.4.9 Уур амьсгалын өөрчлөлт: Дэлхийн дулаарал, цөлжилт, ургамлын талхлагдал, усны хомсдол, хүлэмжийн хийн ялгаруулалт зэрэг сөрөг нөлөөллийг бууруулж, урьдчилан сэргийлэх зорилгоор бэлчээрийн тогтвортой байдлыг дэмжих, мод тарих, ус болон эрчим хүчний хариуцлагатай хэрэглээг нэмэгдүүлэх зэрэг хариу арга хэмжээг аван, бизнесийн үйл ажиллагаанд нийцүүлнэ.
- 2.2.4.10 Барилга, байгууламж төлөвлөлт: Барилга, байгууламжийг төлөвлөхдөө компанийн эзэмшлийн талбай болон орчныхоо 50м хүртэлх нийтийн эзэмшлийн талбайг хамтад нь тохижуулан чухал ач холбогдолтой газар, түүх соёлын өвийг ямагт хамгаална.
- 2.2.4.11 Шинэ барилга барихдаа ногоон зарчмыг баримтлан, эрчим хүч, ус, материалын хэмнэлтийг 20 хувь буюу түүнээс дээш байхаар тооцон, тусгай хэрэгцээт хүмүүст таатай орчинг бүрдүүлнэ.
- 2.2.4.12 Компанийн нийт талбайд эзлэх ногоон байгууламжийн талбайн эзлэх хувийг 15 хувь хүртэл нэмэгдүүлнэ.
- 2.2.5 Нийгэм:
- 2.2.5.1 Хүний нөөц: Хүний нөөцийн эргэцийг 20 хувь хүртэл барин, хүний нөөцийн тогтвортой байдлыг 80 хувь болон түүнээс дээш байлгахаар зохицуулан ажиллана.
- 2.2.5.2 Мерит зарчмыг баримтлан ажилтны ур чадварыг үнэлж урамшуулан, чадварлаг хүний нөөцийг татах, тогтвортой ажиллах соёлыг бэхжүүлнэ.

- 2.2.5.3 Компанийн тогтвортой хөгжлийн үйл ажиллагааны зорилтуудыг хангах хүрээнд ногоон ажлын байрны тоог нэмэгдүүлнэ.
- 2.2.5.4 “Аз жаргалтай ажилтан” гэсэн уриан дор нийт ажилтнуудын ажил болон амьдралын тэнцвэртэй байдлыг дэмжин, ажлын байрны таатай орчныг бүрдүүлж, сэтгэл ханамжийг нэмэгдүүлнэ.
- 2.2.5.5 Ажлын байрны шаардлагын дагуу хөдөлмөр эрхлэх орчныг бүрдүүлж, ажилд авах, цалин олгох, шийдвэр гаргах, сургалт хөгжүүлэлт хийх, урамшуулал олгох, ажлаас гарах, тэтгэвэрт гарах зэрэгт ялгаварлан гадуурхахгүй, ижил тэгш боломжоор ханган ажиллана.
- 2.2.5.6 Компанийн үйл ажиллагаанд хамаарах оролцогч талууд хөдөлмөрийн мөлжлөг, албадсан болон насанд хүрээгүй хүний хөдөлмөр эрхлэлтээс ангид ажиллана.
- 2.2.5.7 Сургалт, хөгжил: Компанийн хэрэгцээ шаардлага, ажилтны хувийн болон карьерийн төлөвлөлтөд үндэслэн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлж, жилд 1~2 удаа сургалтын хүртээмж, үр дүнг тайлагнана.
- 2.2.5.8 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал: ISO 45001:2018 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог үйл ажиллагаандаа нэвтрүүлж, компанийн Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын бодлогын хэрэгжилт, гүйцэтгэлийг жилд нэг удаа тайлагнана.
- 2.2.5.9 Ажлын байрны тодорхойлолтын дагуу ажиллах орчны хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын үзүүлэлтэнд улирал тутамд хяналт тавин, шаардлагыг бүрэн хангасан байна.
- 2.2.5.10 “Нэгдүгээрт аюулгүй байдал” зарчмыг баримтлан, осол дөхсөн тохиолдол, үйлдвэрийн осол мөн мэргэжлээс шалтгаалсан өвчний давтамжийг 0 байлгахыг зорино.
- 2.2.5.11 Хүртээмжтэй байдал: Хүний нөөцийн бодлого, журамд тусгай хэрэгцээт ажилтны ажлын байрны орчин, хөдөлмөрлөх эрх үүргийг тусган, ажлын байрны тоог нэмэгдүүлнэ.
- 2.2.5.12 Нийгмийн хариуцлага: Батлагдсан төсөл, хөтөлбөрийн дагуу хамтын ажиллагаагаар дамжуулан тогтвортой нийгмийн хөрөнгө оруулалтыг жил тутамд хийж, гүйцэтгэлийг 90-ээс дээш хувиар хангана.
- 2.2.5.13 Мэдээллийн аюулгүй байдал: Байгууллагын үйл ажиллагаа болон ажилтнуудтай холбоотой мэдээллийн аюулгүй байдлыг ханган, хэрэглэгчийн хувийн мэдээллийг хамгаалж, эрсдлийг хамгийн бага түвшинд байлгах зорилт тавин ажиллана.

2.2.5.14 Санхүүгийн үйл ажиллагаа: Компанийн жилийн эцсийн санхүүгийн тайланд тогтвортой хөгжлийн зорилгуудыг дэмжихэд чиглэсэн нийт хөрөнгө оруулалт болон зээлийн мэдээллийг тогтмол тайлагнана.

#### 2.2.6 Засаглал:

2.2.6.1 ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын түвшинд тогтвортой хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хянах мөн түүнд хамаарах шийдвэрийг гаргана.

2.2.6.2 Төлөөлөн удирдах зөвлөлд хараат бус гишүүдийн тоог 51 хувиас дээш байхаар зохицуулан, дотоод болон гадаад сонирхогч талуудын эрхийг хамгаалж, тэдгээрийн олон талт оролцоог ханган ажиллана.

2.2.6.3 Компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх дотоод, гадаад сонирхогч талуудын санал гомдлыг хүлээн авах, хэлэлцэх, шийдвэрлэх, хариу өгөх нээлттэй механизмыг сайжруулна.

2.2.6.4 “Амьдралын алхам бүрийг ноолууртай хамт” гэсэн алсын хараандаа зорин ажиллахдаа ажилтан бүр компанийн үнэт зүйлс, ёс зүйн дүрмийг бүрэн ойлгон, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллана.

2.2.6.5 Компанийн үйл ажиллагааны бүтээмжийг тогтмол сайжруулах зорилгоор шинэ мэдлэг, ногоон технологи болон судалгаа хөгжүүлэлтийг дэмжин ажиллана.

2.2.6.6 ISO 9001:2015 Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлж, компанийн бүтэц, үйл ажиллагааны ерөнхий гүйцэтгэлийг сайжруулна.

#### 2.2.7 Салбарын үйл ажиллагаа:

2.2.7.1 Хариуцлагатай татан авалт: Компанийн үйл ажиллагаатай холбоотой худалдан авалтанд байгаль орчин, нийгэмд ээлтэй аргаар үйлдвэрлэсэн бараа материал, үйлчилгээний тоог 30 хувь хүртэл нэмэгдүүлнэ.

2.2.7.2 Бүтээгдэхүүний дижитал паспорт: Тогтвортой түүхий эдээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэн, эцсийн хэрэглэгчид хүргэхдээ нэгж бүтээгдэхүүнтэй холбоотой нөлөөллийн үзүүлэлтүүдийг дэлгэрэнгүй мэдээллэж, бизнесийн үйл ажиллагааны бүтээмж, хэрэглэгчийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлнэ.

2.2.7.3 Хаягдалгүй эдийн засаг: Бүтээгдэхүүн, шошго, сав, баглаа боодол, үйлчилгээнд дахин боловсруулах, байгальд шингэх боломжтой түүхий эд, материалын ашиглалтыг 50 хувь хүртэл нэмэгдүүлэн, бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийг уртасгана.

### 2.3 Зарчим

- 2.3.1 **Нийцэл:** НҮБ болон Монгол улсын тогтвортой хөгжлийн талаарх үзэл баримтлал, “Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Парисын хэлэлцээр”, Даян дэлхийн гэрээний 10 зарчим мөн бусад холбогдох хууль тогтоомж, стандарт, дүрэм журмуудыг баримтлана.
- 2.3.2 **Соёл:** Сонирхогч талуудад тогтвортой хөгжлийн талаарх мэдлэг, ойлголтыг түгээн өдөр тутмын амьдралд нь хэвшүүлнэ.
- 2.3.3 **Нөөцийн зохистой хэрэглээ:** Бид тогтвортой хөгжлийн зорилгод тэмүүлэхдээ, үйл ажиллагаандаа нөөцийн зохистой хэрэглээг баримтлана.
- 2.3.4 **Мэдээллийн үнэн зөв байдал:** Компанийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг дотоод, гадаад сонирхогч талуудад хүргэхдээ мэдээллийн үнэн зөв байдлыг ханган ажиллана.
- 2.3.5 **Харилцан ашигтай байх:** Нийлүүлэлтийн гинжин хэлхээн дэхь бүх сонирхогч талуудын харилцан ашигтай байдлыг нэмэгдүүлэн ажиллана.
- 2.3.6 **Ил тод байдал:** Үйл ажиллагааны ил тод байдлыг эрхэмлэнэ.

## 3. МАНЛАЙЛАЛ БА ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

### 3.1 Тогтвортой хөгжлийн бодлогын үүрэг, хариуцлага

Хүснэгт №1 Тогтвортой хөгжлийн бодлогын хариуцлагын матриц

Процесс	Дээд шатны удирдлага	Дунд шатны удирдлага	Ажилтан	Тогтвортой хөгжлийн хэлтэс
<i>/Г-гүйцэтгэх, Х-хариуцах, З-зөвлөлдөн хамтран ажиллах, М-мэдээлэл авах/</i>				
Тогтвортой хөгжлийн бодлогыг боловсруулах, батлах	ЗМ	М	М	Г, Х
Тогтвортой хөгжлийн бодлогыг нийт ажилтнуудад түгээх, мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх	З	З	М	Г, Х
Оролцогч талуудад тохиромжтой байдлаар хүртээмжтэй байдлыг хангах	Г, З	М	М	Х
Тогтвортой хөгжлийн бодлогыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх	Х, Г	Г	Г	Г
Тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд арга зүйгээр хангах	З	М	М	Г, Х
Шаардлагатай тохиолдолд шинэчлэх	Г, З	З	М	Г, Х

- 3.1.1 Компани нь Тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, гүйцэтгэлийг хянан байнгын сайжруулах замаар тогтвортой хөгжлийн үүрэг амлалт, бодлого болон зорилтуудын нийцлийг хангана.
- 3.1.2 Дээд удирдлага нь компанийн стратегийн төлөвлөгөөнд тогтвортой хөгжлийн бодлого, зорилтуудыг тусгах, бизнесийн үйл явцад нэгтгэх, төлөвлөсөн үр дүнд хүрэх нөхцөлөөр хангана.
- 3.1.3 Дунд шатны удирдлага нь Тогтвортой хөгжлийн бодлого, зорилтыг хэрэгжүүлж, байнгын сайжруулалтыг дэмжих, үр нөлөөтэй байдлыг хангах зорилгоор ажилтнуудын оролцоог хангана.
- 3.1.4 Ажилтан нь компанийн Тогтвортой хөгжлийн үүрэг амлалт, бодлого, зорилтуудыг дэмжиж, идэвхи санаачлагатай оролцож, Тогтвортой хөгжлийн зарчмыг баримтлан ажиллана.
- 3.1.5 Тогтвортой хөгжлийн хэлтэс нь Тогтвортой хөгжлийн бодлого, зорилтыг боловсруулан батлуулах, хэрэгжүүлэх, хяналт тавих, тасралтгүй сайжруулах үүргийг хүлээнэ. Нийт сонирхогч талуудыг мэдээллээр ханган ажиллана.

ТӨГСӨВ.

**4. ХАВСРАЛТ****4.1 Нэгдсэн Үндэсний Байгууллагын Тогтвортой Хөгжлийн 17 зорилго***Зураг №1 Эх сурвалж: <http://sdg.gov.mn/>***4.2 Даян дэлхийн гэрээний 10 зарчим****Хүний эрх**

- Зарчим 1. Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хамгаалах олон улсын тунхаглалуудыг хүндэтгэх дэмжих;
- Зарчим 2. Бизнесийн үйл ажиллагааг хүний эрхийн аливаа зөрчлийн хамтрагч болгохгүй байх;

**Хөдөлмөр эрхлэлт**

- Зарчим 3. Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, хамтын хэлэлцээр байгуулах эрхийг үр ашигтайгаар хүлээн зөвшөөрөх;
- Зарчим 4. Хүчээр болон албадан хөдөлмөрлүүлэх аливаа хэлбэрийг арилгах;
- Зарчим 5. Хүүхдийн хөдөлмөрийг арилгах;
- Зарчим 6. Ажил эрхлэх, албан тушаал хашихад ялгаварлан гадуурхах байдлыг арилгах;

**Байгаль орчин**

- Зарчим 7. Бизнесийн үйл ажиллагаанд байгаль орчны аливаа өөрчлөлт доройтлоос урьдчилан сэргийлэх;
- Зарчим 8. Бизнесийн үйл ажиллагаанд байгаль орчны хариуцлагыг өндөржүүлэх;
- Зарчим 9. Байгаль орчинд ээлтэй технологийг хөгжүүлэх, нэвтрүүлэх;

**Авлига**

- Зарчим 10. Авлига, хээл хахуулийн бүх хэлбэрийн эсрэг тууштай үйл ажиллагаа явуулах;